

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2025 оны II улирлын санхүүгийн тайлан

Агуулга

Хүснэгтийн жагсаалт	3
Зургийн жагсаалт	3
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН.....	4
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	5
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	6
Батлан даалт, байршил.....	7
Батлан даалт, зээлдэгчдийн үйл ажиллагааны чиглэл.....	8
Зээлдүүлэгч болон батлан даалтын эх үүсвэр	9
Зээлийн болон батлан даалтын чанар	10
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.....	12
САНАЛ, ДҮГНЭЛТ	13

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Батлан даалтын хүсэлтийн тоо	6
Хүснэгт 2 Зээл, батлан даалтын дүн, тоо (дүүргээр).....	7
Хүснэгт 3 Зээл, батлан даалтын дүн, тоо (аймгаар)	7
Хүснэгт 4 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	12

Зургийн жагсаалт

Зураг 1 Нийт хөрөнгө (тэрбум төгрөгөөр).....	5
Зураг 2 Эх үүсвэрийн бүтэц (хувиар).....	5
Зураг 3 Нийт орлого, цэвэр ашиг (тэрбум төгрөгөөр).....	5
Зураг 4 Нийт орлого, зардал (тэрбум төгрөгөөр).....	5
Зураг 5 Зээл, батлан даалтын үлдэгдэл (тэрбум төгрөгөөр)	6
Зураг 6 Зээл, батлан даалтын дүн (тэрбум төгрөгөөр)	6
Зураг 7 Батлан даалтын дүн, тоо (бүс нутгаар).....	7
Зураг 8 Батлан даалтын бүтэц (үйл ажиллагааны чиглэлээр)	8
Зураг 9 Батлан даалтын хэмжээ (банкаар).....	9
Зураг 10 Батлан даалтын бүтэц (эх үүсвэрээр)	9
Зураг 11 Зээлийн чанар (хувиар)	
Зураг 12 Батлан даалтын чанар (хувиар)	10
Зураг 13 Чанаргүй батлан даалтын хувь, зээлдэгчдийн тоо	10
Зураг 14 Үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын дүн, тоо	11

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг баталж, 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Зээлийн батлан даалтын сан байгуулагдсан. Зээлийн батлан даалтын сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, хуулийн этгээд, жижиг дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалт гаргах ашгийн төлөө бус хуулийн этгээд юм.

Засгийн газраас хэрэгжүүлж буй төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд 2021 онд Улсын Их Хурлаас тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, 9 дүгээр зүйлийн 9.1.3-т “төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах” гэж заасан. Үүний дагуу 2023 оноос эхлэн 21 аймаг болон Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүргүүдэд банк, санхүүгийн байгууллагаас орон сууцны ипотекийн 6 хувийн хүүтэй зээл авахыг хүссэн, ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн дутагдалтай этгээдэд урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргаж эхэлсэн.


Мөн Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиар Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-т “уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх хоршооны гишүүн малчинд урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 100 хүртэлх хувьд батлан даалт гаргах.” гэж нэмсэн.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөлийн 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаар тогтоолоор Зээлийн батлан даалтын сангийн дүрэмд 3 заалтыг өөрчлөн найруулахаар, 9 заалтад нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэж, Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлтээ ирүүлсэн ба Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлээр Зээлийн батлан даалтын сангийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны эхний хагас жилийн байдлаар Зээлийн батлан даалтын сангийн нийт хөрөнгө 313.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.1 хувиар буюу 12.3 тэрбум төгрөгөөр өссөн ба үүнд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт голлон нөлөөлж байна.

Зураг 1 Нийт хөрөнгө (тэрбум төгрөг)




Тайлант үеийн Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг бүтцээр нь задалж үзвэл 64 хувийг өр төлбөр, 36 хувийг цэвэр хөрөнгө бүрдүүлж байна. Нийт өр төлбөрийн 2.1 хувь нь богино хугацаат өр төлбөр бол үлдсэн 97.9 хувь нь урт хугацаат зээл, зээлийн хүүгийн өглөг байна.

Зураг 2 Эх үүсвэрийн бүтэц (хувиар)




Тайлант үеийн нийт орлого 15.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 1.6 дахин их буюу 5.7 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Харин тайлант улиралд 200.0 сая төгрөгийн алдагдал хүлээхэд үйл ажиллагааны зардлын өсөлт голлон нөлөөлж байна.

Зураг 3 Нийт орлого, цэвэр ашиг (тэрбум төгрөг)



Нийт орлогын 90.3 хувийг сангийн хүүгийн орлого, 9.7 хувийг батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хураамжийн орлого бүрдүүлж байгаа бол нийт зардлын 100 хувийг ерөнхий удирдлагын зардал бүрдүүлж байна.


Зураг 4 Нийт орлого, зардал (тэрбум төгрөг)



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зээлийн батлан даалтын сантай 11 банк, 5 банк бус санхүүгийн байгууллага хамтран ажиллах гэрээ байгуулсан ба 2025 оны эхний хагас жилийн байдлаар 7 банкны 14,816 зээлдэгчдийн 779.6 тэрбум төгрөгийн зээлд 448.2 тэрбум төгрөгийн батлан даалтын үлдэгдэлтэй гарсан нь 2024 оны мөн үеэс тус тус 1.8 дахин өссөн үзүүлэлт бөгөөд нийт зээлийн үлдэгдлийн 56.1 хувийг тус сангаас батлан даасан байна.

Зураг 5 Зээл, батлан даалтын үлдэгдэл (тэрбум төгрөг)




Энэ оны эхний хагас жилийн байдлаар батлан даалтын санд нийт 1,376 хүсэлт ирүүлснийг 100 хувь батлан даах шийдвэр гаргасан бөгөөд Монгол Улсын Засгийн газраас баталсан “Төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлого” болон “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд батлан даалт гаргуулах сонирхолтой иргэдийн хүсэлт голлон нөлөөлжээ.

Хүснэгт 1 Батлан даалтын хүсэлтийн тоо

Батлан даалтын хүсэлт	2021.И	2022.И	2023.И	2024.И	2025.И
Ирүүлсэн хүсэлтийн тоо	241	38	132	5,441	1,376
Зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо	180	23	102	5,441	1,376
Эзлэх хувь	75%	61%	77%	100%	100%

2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1,376 зээлдэгчийн 84.9 тэрбум төгрөгийн зээлд 42.8 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан нь 2024 оны мөн үеэс 4 дахин буурсан дүн юм. Нэг батлан даалтын дундаж хэмжээ нь 31.1 сая төгрөг байгаа нь өмнөх 4 жилийн дундажтай харьцуулахад 5.8 дахин бага байна. Үүнд хоршооны гишүүн малчдад гаргасан батлан даалт голлон нөлөөлж байгаа ба нэг малчинд олгосон дундаж зээлийн хэмжээ 33.5 сая төгрөг, батлан даалтын дүн 23.1 сая төгрөг байна.

Зураг 6 Зээл, батлан даалтын дүн (тэрбум төгрөг)



Тайлант хугацаанд Улаанбаатар хотын 20 зээлдэгчийн 15.7 тэрбум төгрөгийн зээлд 7.3 тэрбум төгрөг, орон нутгийн 1,356 зээлдэгчийн 69.2 тэрбум төгрөгийн зээлд 35.5 тэрбум төгрөгийн батлан даалт тус тус гаргасан байна.

Батлан даалт, байршил

2025 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн 7 дүүрэгт 20 зээлдэгчийн 15.7 тэрбум төгрөгийн зээлд 7.3 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан ба нийт зээлийн 90 хувь буюу 14 зээлдэгчийн 14.0 тэрбум төгрөгийг Азийн хөгжлийн банкны МОН-3338 төслөөс санхүүжүүлсэн байна.


Нөгөөтэйгүүр, Баянгол дүүргийн хувьд батлан даалтад хамрагдагсдын тоо идэвхжиж 4 зээлдэгчийн 4.2 тэрбум төгрөгийн зээлд хамгийн өндөр дүнгээр буюу 1.9 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна.

Хүснэгт 2 Нийслэлд гаргасан зээлийн батлан даалтын дүн, тоо (сая төгрөгөөр)

Дүүрэг	Зээлийн дүн	Батлан даалтын дүн	Батлан даалтын тоо
Баянгол	4,240.0	1,918.1	4
Баянзүрх	4,215.0	1,889.4	5
Сонгинохайрхан	4,208.0	1,861.0	6
Хан-Уул	2,200.0	1,171.1	3
Чингэлтэй	700.0	420.0	1
Налайх	105.6	21.6	1
Улаанбаатар хот	15,668.6	7,281.10	20

Тайлант хугацаанд гаргасан батлан даалтыг бүс нутгаар ангилж үзвэл хангайн бүсэд хамгийн их буюу 910 зээлдэгчийн 41.9 тэрбум төгрөгийн зээлд 22.6 тэрбум төгрөгийн, харин зүүн бүсэд хамгийн бага буюу 171 зээлдэгчийн 11.5 тэрбум төгрөгийн зээлд 5.5 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна.

Зураг 7 Батлан даалтын дүн, тоо (бүс нутгаар)



Орон нутагт гаргасан нийт батлан даалтын 13.8 хувийг хуулийн этгээдэд, 86.2 хувь нь иргэдэд гаргасан байх ба орон нутгийн 1,338 иргэнд гаргасан 30.6 тэрбум төгрөгийн батлан даалтын 3.3 тэрбум төгрөг нь ипотекийн зээл, 27.3 тэрбум төгрөг нь “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд гаргасан батлан даалт байна.

Хүснэгт 3 Орон нутагт гаргасан Зээл, батлан даалтын дүн, тоо (сая төгрөгөөр)


Аймаг	Зээлийн дүн	Батлан даалтын дүн	Батлан даалтын тоо
Баянхонгор	11,656.8	8,499.6	359
Хөвсгөл	9,014.4	5,081.6	230
Булган	5,502.7	3,042.0	115

Архангай	4,893.8	2,969.4	127
Хэнтий	3,811.6	2,938.4	105
Дорнод	6,604.9	2,362.7	55
Орхон	8,031.0	1,906.2	55
Говь-алтай	3,396.0	1,611.5	80
Дундговь	2,150.8	1,194.0	54
Өвөрхангай	2,828.7	1,048.3	24
Төв	1,582.0	872.5	35
Дархан-Уул	1,994.2	847.4	7
Сэлэнгэ	1,754.6	663.8	13
Өмнөговь	1,402.6	624.1	14
Завхан	994.0	591.9	30
Увс	1,165.6	519.5	24
Дорноговь	987.0	292.6	12
Сүхбаатар	1,052.7	222.8	11
Ховд	337.0	157.4	5
Говьсүмбэр	50.0	40.0	1
Баян-Өлгий	-	-	0
Нийт	69,210.4	35,485.70	1356

Батлан даалт, зээлдэгчдийн үйл ажиллагааны чиглэл

2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт гаргасан батлан даалтын 63.9 хувийг мал аж ахуй буюу тэр дундаа “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий малчид, 11.4 хувийг бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа, 7.8 хувийг ипотекийн зээл, 6.8 хувийг боловсруулах үйлдвэр, 4.2 хувийг эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа, үлдсэн 5.9 хувийг бусад салбар тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд нийт 35 хуулийн этгээдийн 26.4 тэрбум төгрөгийн зээлд 12.1 тэрбум төгрөгийн батлан даалт гаргажээ.


Зураг 8 Батлан даалтын бүтэц (үйл ажиллагааны чиглэлээр)



Зээлдүүлэгч болон батлан даалтын эх үүсвэр

Тайлант хугацаанд доорх 7 арилжааны банкны зээлд батлан даалт гаргасан ба Хаан банкны 41.3 тэрбум төгрөгийн зээлд 24.1 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан нь нийт батлан даалтын 56.4 хувийг эзэлж байна. Худалдаа хөгжлийн банкны 13.4 тэрбум төгрөгийн зээлд 4.7 тэрбум төгрөгийн, Төрийн банкны 13.3 тэрбум төгрөгийн зээлд 7.8 тэрбум төгрөгийн, Голомт банкны 8 тэрбум төгрөгийн зээлд 2.9 тэрбум төгрөгийн, Капитрон банк, Хас банк, Ариг банк зэрэг санхүүгийн байгууллагуудын 8.9 тэрбум төгрөгийн зээлд 3.3 тэрбум төгрөгийн батлан даалт тус тус гаргасан байна. Хамгийн их батлан даалттай зээл олгосон Хаан банкны хувьд хоршооны гишүүн малчдад олгосон зээлийн батлан даалтын хэмжээ 20.1 тэрбум төгрөг байгаа нь тухайн банканд гаргасан батлан даалтын 83.4 хувийг эзэлж байна.


Зураг 9 Батлан даалтын хэмжээ (банкаар)



Эх үүсвэрийн хувьд авч үзвэл тайлант үед гарсан нийт батлан даалтын 63.9 хувь буюу 27.3 тэрбум төгрөгийг “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бол 23.9 хувийг Азийн хөгжлийн банкны МОН-3338 төсөл, 7.8 хувийг ипотекийн зээлийн санхүүжилт, үлдсэн 4.4 хувийг Атрын 4 аян, ЖДҮХС-ийн төсөл, банкны өөрийн болон цагаан алт зэрэг

бусад эх үүсвэрээс тус тус санхүүжүүлсэн байна.

Зураг 10 Батлан даалтын бүтэц (эх үүсвэрээр)



Зээлийн болон батлан даалтын чанар

Батлан даасан нийт 14,816 зээлдэгчийн 799.6 тэрбум төгрөгийн зээлийн 14,699 зээлдэгчийн 771.2 тэрбум төгрөгийн зээл хэвийн ангилалд байгаа нь нийт зээлийн багцын 96.5 хувийг эзэлж байна. Ангилал буурсан зээлийн хувьд 69 зээлдэгчийн 11.7 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 48 зээлдэгчийн 16.7 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд шилжсэн байна.

Харин батлан даалтын чанарыг харвал 14,745 зээлдэгчийн 434.2 тэрбум төгрөгийн батлан даалт хэвийн, 24 зээлдэгчийн 6 тэрбум төгрөгийн батлан даалт хугацаа хэтэрсэн, 47 зээлдэгчийн 8 тэрбум төгрөгийн батлан даалт чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Зураг 11 Зээлийн чанар (хувиар)




Зураг 12 Батлан даалтын чанар (хувиар)



2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт батлан даалтад эзлэх чанаргүй батлан даалтын хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр буурч 1.8 хувьд хүрэхэд нийт батлан даалтын хэмжээ нэмэгдсэн, чанаргүй батлан эргэн төлөлт сайжирсан нь батлан даалтын чанарт сайнаар нөлөөлж байна.


Зураг 13 Чанаргүй батлан даалтын хувь, зээлдэгчдийн тоо



2025 оны эхний хагас жилийн байдлаар банкнаас чанаргүй ангилалд шилжсэн 62 зээлдэгчийн 8.2 тэрбум төгрөгийн зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Зээлийн батлан даалтын санд ирүүлсэн нэхэмжлэлийн 7.5 тэрбум төгрөгийн үүргийн гүйцэтгэлийг хангаж, 47 зээлдэгчээс 1.7 тэрбум төгрөгийн авлагыг эргэн төлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Үүрэг гүйцэтгэсэн баятлан даалтын сүүлийн 5 жилийн статистикийг харвал нэхэмжилсэн дүн дунджаар 70.7 хувиар, үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын дүн дунджаар 68.3 хувиар тус тус өссөн байна.

Зураг 14 Үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын дүн, тоо



ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор баталсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын дагуу Сан нь дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллахаар зохицуулсан байдаг. Үүний дагуу 2025 оны эхний хагас жилийн тайлангаар зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг харвал нийт 13 шалгуур үзүүлэлтийг бүгдийг нь хангасан байна.

Хүснэгт 4 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР	ХАНГАСАН ЭСЭХ
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ			
Өөрийн хөрөнгийн байвал доод хэмжээ	5,000,000,000.00	112,046,955,630.46	Хангасан
Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт	10%-аас доошгүй	35.8%	Хангасан
Гаргасан төлбөрийн баталгаа өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	10 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй	448,215,093,930.23	Хангасан
ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА			
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	100%-аас доошгүй	131%	Хангасан
АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, зээлийн зохистой харьцаа	60%-аас хэтрэхгүй	60.0%	Хангасан
Хоршооны гишүүн малчинд гаргах батлан даалт, зээлийн зохистой харьцаа	100%-аас хэтрэхгүй	100.0%	Хангасан
Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	1.1%	Хангасан
Өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	40%-аас хэтрэхгүй	0.0%	Хангасан
Урт хугацаат өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	0.0%	Хангасан
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА			
Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	14.1%	Хангасан
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	1.4%	Хангасан
НӨӨЦИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ			
Нөөцийн сангийн хүрэлцээний үзүүлэлт	(85,795,891.67)	28,923,037,052.59	Хангасан
ЧАНАРГҮЙ БАТЛАН ДААЛТЫН ҮЛДЭГДЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА			
Чанаргүй батлан даалтын үлдэгдлийн зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	1.8%	Хангасан

САНАЛ, ДҮГНЭЛТ

2025 оны эхний хагас жилийн байдлаар Зээлийн батлан даалтын сангийн нийт хөрөнгө 313.0 тэрбум төгрөгт хүрч, 2024 оны мөн үеэс 4.1 хувиар өссөн бол нийт орлогын хэмжээ 15.7 тэрбум төгрөгт хүрлээ.

Тайлант үеийн хугацаанд шинээр 1,376 зээлдэгчийн 84.9 тэрбум төгрөгийн зээлд 42.8 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаж, 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн тайлангаар нийт 14,816 зээлдэгчийн 799.6 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлд 448.2 тэрбум төгрөгийн батлан даалтын үлдэгдэл бүртгэсэн байна.

Тайлант үеийн хугацаанд Улаанбаатар хотын 20 зээлдэгчийн 15.7 тэрбум төгрөгийн зээлд 7.3 тэрбум төгрөгийн, орон нутгийн 1,356 зээлдэгчийн 69.2 тэрбум төгрөгийн зээлд 35.5 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан ба батлан даалтад хамрагдсан зээлдэгчдийн 97.4 хувь нь иргэн, 2.6 хувь нь хуулийн этгээд байна. Улаанбаатар хотын хувьд Баянгол дүүрэгт хамгийн их буюу 4 зээлдэгчид 1,918.1 сая төгрөгийн батлан даалт гаргасан бол орон нутагт Баянхонгор аймагт хамгийн их буюу 359 зээлдэгчид 8,499.6 сая төгрөгийн батлан даалт гаргажээ.

Зээлийн батлан даалтын сангаас 2025 оны эхний хагас жилийн байдлаар нэр бүхий 7 арилжааны банкны зээлд батлан даалт гаргасан ба хамгийн их батлан даалттай Хаан банкны хувьд “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хоршооны гишүүн малчдад олгосон зээл тухайн банканд гаргасан батлан даалтын 83.4 хувийг эзэлж байна.

Тайлангийн хугацаанд шинээр гаргасан батлан даалтын 63.9 хувь буюу 27.3 тэрбум төгрөгийг “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд төрөөс төсвийн хөрөнгөөр, үлдсэн 36.1 хувийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна.

Батлан даасан зээлийн чанарыг харвал 14,699 зээлдэгчийн 771.2 тэрбум төгрөгийн зээл хэвийн, 117 зээлдэгчийн 28.4 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн болон чанаргүй ангилалд шилжиж нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 2.1 хувь болж нийт батлан даалтад эзлэх чанаргүй батлан даалтын хувь 1.8 хувь болж буурлаа. Сүүлийн 5 жилийн батлан даалтын үүргийн гүйцэтгэлийн мэдээгээр зээлдүүлэгчдээс нэхэмжилсэн дүн, үүрэг гүйцэтгэсэн дүн дунджаар 65-75 хувиар нэмэгдэж байгаа тул зээлийн болон батлан даалтын чанарт онцгой анхаарах хэрэгтэй байна.

Шинээр батлан даасан зээлдэгчдийн үйл ажиллагааны чиглэлийг харвал батлан даалтын 63.9 хувийг Хоршооны гишүүн малчид, 11.4 хувийг бөөний болон жижиглэн худалдааны бизнес эрхлэгчид, 7.8 хувийг ипотек, 6.8 хувийг боловсуулах үйлдвэр, үлдсэн 10.1 хувийг бусад төрлийн үйл ажиллагаа эзэлж байгаа нь эдийн засгийн салбаруудад батлан даалтын хүртээмж жигд бус байгааг илтгэж байна. Тиймээс эдийн засгийн бусад салбарт тэр дундаа нэмүү өртөг шингээсэн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгчдэд батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

2025 оны эхний хагас жилийн тайлангаар Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохистой харьцааны 12 шалгуур үзүүлэлт нь 13 болон нэмэгдсэн ба бүх үзүүлэлтийг хангаж ажилласан байна.